



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 153

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орхон аймаг дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 7 нэрийн, нийт 6,532,683.00 (зургаан сая таван зуун гучин хоёр мянга зургаан зуун наян гурван) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 798,000.00 (долоон зуун ерэн найман мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Орхон аймгийн Гаалийн газрын дарга Б.Майдармаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001376

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 05 дугаар сарын 20-ны
өдрийн /53/ дугаар тогтоолын хавсралт

**Орхон аймаг дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх
өртөггүй, хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах үнийг шинэчлэн тогтоох
хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиг лалтад орсон он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчилсэн үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	LNB долгион хүлээн авагч	2014	ш	1	275,000.00	27,500.00	1
2	BUC долгион дамжуулагч	2014	ш	1	1,650,000.00	165,000.00	1
3	Feedhorn дуран	2014	ш	1	550,000.00	55,000.00	1
4	Skyedge IP VSAT	2014	ш	1	2,915,000.00	291,500.00	1
5	Биллярдын үирээ	2004	ш	1	800,000.00	240,000.00	3
6	Теннисний ширээ	2007	ш	1	155,000.00	46,500.00	3
7	Хурлын сандаг	2007	ш	10	187,683.00	56,304.00	3
	ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН				6,532,683.00 (зургаан сая таван зуун гучин хоёр мянга зургаан зуун наян гурван)	798,000.00 (долоон зуун ерэн найман мянга)	